



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

158 /158/

2021.10.18

ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

1937 он:

Г.САЙХАНБАЯР: ЦЭРГИЙН АЛБЫГ 1.6-2 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ, ХҮН БҮР ХААДАГ ТОГТОЛЦОО РУУ ШИЛЖИНЭ

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын www.Ergelt.mn сайтад өгсөн ярилцлагаас онцлох мэдээллүүдийг иш татан хүргэж байна.



Цэргийн цолны зохистой харьцаа, цэргийн цолыг журамлах ажлын хэсгийг ахалж байна. Энэ ажил маш амжилттай үргэлжилж байгаа. Бэлтгэл цол ч мэдэгдэхгүй, энгийн цол, жинхэнэ цэргийн цол ч мэдэгдэхгүй цэргийн цол зүүсэн иргэн маш олон байна. Мөн цэргийн хууль, дүрэм журамтай хувцсыг хэн хамаагүй хүссэн үедээ өмсөж, хаа сайгүй зарж борлуулж, солилцож, дамжуулж байгаа. Эдгээрийг ажлын хэсэг цэгцлэх юм. Үүний хүрээнд төрийн цэргийн байгууллагуудын бүх төлөөлөл ажлын хэсэгт орсон. Бид ажлаа ойрын хугацаанд Ерөнхийлөгчид илтгэнэ.

Нийгэм, соёл урлагийнхан, бөхчүүд, төр захиргааны байгууллагуудын албан тушаалтнууд, орон нутгийн засаг захиргааны дарга нарт цэргийн бэлтгэл цол олгох нь маш буруу. Зөвхөн байлдааны сургууль дадлагад оногдсон үүргээ биелүүлж

байгаа байлдагч, дэслэгч нарт бэлтгэл цол олгох ёстой.

Энэ жилээс бид хугацаат алба хаагчдад цэргийн анхан шатны болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхээр төлөвлөж байна. Залуучууд хугацаат цэргийн албанд ирээд хөдөлмөрийн амт шимт, мэргэжлийн арга технологийг эзэмшиж мэргэжилтэй болно гэдэг маш том хөрөнгө оруулалт шүү дээ. Аль ч нийгэмд хөдөлмөрлөсөн хүн сайхан амьдардаг жамтай. Тиймээс бид цэргийн албанд ирж буй залууст байлдааны зэвсэг, техник эзэмшүүлээд явуулах биш нийгэмд зөв боловсон иргэнийг бэлдэж өгөхөөр ажиллаж байна.

Манай офицер, ахлагч нар цэргийн алба хаагчдыг эх оронч үзэлтэй болгож төлөвшүүлэх, хүмүүжүүлэх үүрэгтэй. Энэ чиг үүргийнхээ хүрээнд Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын хандлагыг өөрчилж байгаа. Тэд зөвхөн сайн

бууддаг, гүйдэг, гадаад хэл сайн эзэмшсэн зэрэг хувийн асуудлаа шийдсэнээр Зэвсэгт хүчний салбар болон Монгол Улс хөгжихөд төдийлөн нөлөөлөхгүй. Тэд алба хаагчдыг цэргийн мэргэжил, энгийн мэргэжил эзэмшүүлж хувь хүн болгон төлөвшүүлж, боловсролтой болгож, нийгэмшүүлэхэд анхаарч ажиллах цаг болсон. Офицер, ахлагч нарын хандлагыг өөрчилснөөр цэрэгт ирж буй залуус нийгэмд тодорхой хэмжээгээр бэлтгэгдсэн, нийгэмшсэн, хүнтэй ажиллаж сурсан бие хүн болж төлөвшинэ. Тиймээс офицер, ахлагч нарын хандлагыг өөрчлөх тал дээр анхаарч ажиллаж байгаа.

Манай салбартай холбоотой дэгдсэн асуудлаас үүдэн би дөрвөн тушаал, шийдвэр гаргасан.

Нэгдүгээрт, салаа удирдаж буй офицер, ахлагч нарын мэдлэг, ёс зүйн түвшин тогтоох үзлэгийг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

Хоёрдугаарт, Батлан хамгаалах яаманд 24 цагийн 18001144 утас ажиллаж байгаа. Тус утас руу залгаж хугацаат цэргийн алба хаагчид, үр хязгаарлагдмал нь холбоотой тодорхой мэдээллүүдийг ямар ч цаг үед авах, мэдээлэх боломжтой. Мөн цэргийн алба хаагчид болон манай салбартай холбоотой санал хүсэлтээ хүргүүлж болно.

Гуравдугаарт, цэргийн ангиудад ямар ч архивалт байхгүй гэдгийг хатуу сануулж, түүнчлэн ахуйн хэрэглээнд архины шил хэрэглэхийг хориглосон.

Дөрөвдүгээрт, хугацаат цэргийн алба хаагчидтай ангиудын цэргийн байр, анги танхим, хичээлийн орчныг 100 хувь камержуулсан. Тиймээс цэргийн алба хаагчид нууц, хязгаарлагдмал орчинд байдаг гэх хуучин ойлголт өөрчлөгдсөн.

Зэвсэгт хүчний хугацаат цэргийн алба хаагчтай, мэргэжлийн бие бүрэлдэхүүнтэй ангиудад

мэргэжлийн сэтгэл зүйч нарын орон тоо бий болгож мэргэшүүлж, ажлуулсан. Энэ намраас Үндэсний Батлан хамгаалахын их сургуульд цэргийн сэтгэл зүйч бэлтгэх сургалт эхэлсэн.

Цар тахлын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор бүтэн жилийн хугацаанд цэрэг татаагүй. Энэ удаад ээлжит цэрэг татлагыг зохион байгуулахаар комисс гарган ажиллаж байна. Цэргийн зарлан авсан иргэдээ бүртгэлжүүлж, халдвар хамгаалалтыг сахиж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана. Хаврын цэрэг татлага болоогүй учраас энэ удаад олон цэрэг авах ёстой.

Энэ жилийн төсөв онцлогтой. Тухайлбал, хугацаат цэргийн алба хаагчийн ном, соёлын арга хэмжээний зардал гэж байдаг. Сүүлийн тав, зургаан жил төсөвт тусгагдаагүй байсан. Үүнд төсөв батлуулсан. Тиймээс цэргүүдэд үзвэр үйлчилгээ, кино үзүүлэх боломжтой болсон. Мөн манай нийт бүрэлдэхүүний хувцасны зардалд жил бүр 40-50 хувьтай л төсөв батлагддаг байсан. Энэ жил 100 хувь батлагдсан. Манай салбарт баталсан улсын төсвийн 90 гаруй хувь нь урсгал зардал буюу үйл ажиллагаанд зориулагддаг. Харин бүтээн байгуулалтын төсөв маш бага хувийг эзэлдэг.

Зэвсэгт хүчний хэмжээнд хүн нэг бүрийн гар бууг сайжруулж, богино хугацаанд олон буудалт хийдэг болгосон. Энэ бол маш том дэвшил, улам өргөжих ёстой. Манай улс 10 жилийн дараа галт зэвсэг, автомашин, техникийн үйлдвэртэй болно. 100 жилийн түүхэндээ манай улс нэг ч зэвсэг дотооддоо үйлдвэрлэж байгаагүй. Бид ирэх жилийн төсөв хөрөнгө оруулалтаас сумны үйлдвэртэй болохыг зорьж байна.

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ЖАНЖИН ТУГАНДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй UN-MISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний Жанжин туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагааг өнгөрсөн ням гарагт зохион байгууллаа.

Тавантолгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулсан энэхүү ёслолын ажиллагаанд БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Т.Буянбат болон БНӨСУ-д үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн цэргийн багийн

удирдлага, бие бүрэлдэхүүн оролцсон юм.

ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг Зэвсэгт хүчний Жанжин тугийг залснаар энэхүү ёслол эхэлж, Цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний Жанжин тугандаа хүндэтгэл үзүүлсэн юм.

Үүний дараа БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ хэлсэн үгэндээ "Монгол Улсын Зэвсэгт хүчин анхны цэргийн ажиглагч офицерыг үүрэг гүйцэтгүүлэхээр илгээснээс хойших 19 жилийн хугацаанд дэлхийн 13 улсад явагдсан 17 энхийг дэмжих ажиллагаанд давхардсан тоогоор 19500 гаруй цэргийн алба хаагч, энхийг сахиулагч нар үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн юм.

Үргэлжлэл нь II нүүрт!

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
330.961 +1643

ЭДГЭРСЭН
433.470 +7118

НАС БАРСАН
1454 +14

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
5676 +98

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
189

ЭДГЭРСЭН
5378

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 241,471,559

Эдгэрсэн

Нийт: 218,700,016

Нас барсан

Нийт: 4,914,092

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

ЖАРГАЛ ИРНЭ.

Наран ургах, шингэх:
07.16-17.59

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал:

Авахуй

Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хаагаа хийлгэх, биеийн тамырыг сэргээх, нялхсын хурим хийх, сүм дуганыг сэргээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн.

Газар ухах, худаа гаргах, гөлөг тэжээх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ЖАНЖИН ТУГАНДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



ажиллагааны газар оронд үүргээ амжилттай гүйцэтгэн, "Дэлхийн цэрэг" хэмээн хүндлэгдсэн Монгол цэргийнхээ нэр хүндийг өндөрт өргөхийг ерөөлөө.

Мөн энэ үеэр БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын мандаттай UNMISS ажиллагаанд мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэх дайчин нөхдөдөө хандаж, цэргийн багийн захирагч, хурандаа О.Заяат үг хэлсэн юм. Тэр бээр хэлсэн үгэндээ БНӨСУ-д явагдаж буй ажиллагаанд үүргээ амжилттай гүйцэтгэсэн өмнөх багуудын нэр их хөдөлмөр, хичээл зүтгэлээр бий болсон ололт амжилтыг улам бүр бататгаж, энх тайван, тогтвортой байдлыг хангах ариун үйлсэд хувь нэмрээ оруулах гэж байгаа нь бидний хувьд нэр төрийн хэрэг юм. Дэлхий дахинд болон манай оронд тархсан цар тахлын хүнд үед цэргийн багийн бие бүрэлдэхүүн "Түргэн сэтгэ, дасан зохиц, итгэлийг зүтгэлээр ялан дийл" гэсэн уриаг дэвшүүлэн халдвар хамгааллын дэглэмийг

чанд сахисны үндсэн дээр ажиллагааны өмнөх сургалт бэлтгэлийг өндөр түвшинд чанартай, тасралтгүй, өндөр хариуцлагатайгаар зохион байгууллаа. Энэхүү сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн ЗХЖШ, Ажиллагааны удирдлагын газар, Зэвсэгт хүчний 311 дүгээр анги, Энхийг дэмжих сургалтын төвийн хамт олонд талархсанаа илэрхийлж гэдгийг тодотгов.

Ёслолын ажиллагааны үеэр ЗХЖШ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн ЦДУ-ын офицер, дэслэгч А.Оюунболдод албан тушаалын зэрэглэлийн ахлах дэслэгч цол, мөн 013 дугаар ангийн цэргийн гэрээт алба хаагч, түрүүч Б.Буянжаргал, Ө.Төрмөнх нарт дэд ахлагч цол олгосныг нь гардуулан өглөө.

Түүний дараа ЦДБЭЧ-ын голлол дуучин, СТА Н.Түвшинжаргал "Хэнгэрэг дэлхийн цэрэг" дуугаар ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн бол Цэргийн



баг, бүрэлдэхүүний сүлд дуу болгон шинээр зохиосон дэд хурандаа Б.Мөнх-Учралын үг, ая "Зүрхний эх орон" дууг дэд ахлагч Б.Энхжаргал, М.Энхбат нар дуулсан нь энэхүү ёслолын ажиллагааны ач холбогдлыг нь улам бүр өргөсөн юм.

Энэхүү Зэвсэгт хүчний Жанжин туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаа Цэргийн багийн

бие бүрэлдэхүүний ёслолын жагсаалаар үргэлжлэн, Жанжин тугийг байнгын байрлалд эргүүлэн залснаар өндөрлөв.

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 11 дүгээр ээлжийн Цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүнд улам их амжилтыг бэлгэдэн өрөөе.

Хурандаа
Б.ОТГОНБАЯ

Түрүүч нь I нүүрт/ Өнөөдөр дэлхий нийтээр цар тахлын халдвар тархсан эрсдэлтэй цаг үед НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 900 орчим цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэж байна. Та бүхэн төр, засгийн удирдлагаас хүлээлгэсэн нэр хүндтэй бөгөөд өндөр хариуцлагатай үүргийг цэргийн хэргийн мэдлэг, дадлага, туршлагадаа тулгуурлан

амжилттай гүйцэтгэж, Цэргийн багийн удирдлагаас гаргасан шийдвэрийг ёсчлон биелүүлэн, бие биедээ анхаарал тавьж, үүргээ нэр төртэй гүйцэтгэнэ гэдэгт итгэл төгс байна" гэдгийг онцоллоо.

Тэрбээр үг хэлснийхээ дараа Цэргийн багийн захирагч, хурандаа О.Заяатад Монгол Улсын Төрийн далбааг гардуулж,

Цахим шууданд

ДАЙЧИД АЙМГИЙН ТҮҮХЭН ДУРСГАЛТ ГАЗРААР АЯЛАВ



Зэвсэгт хүчний 338 дугаар анги 2020 оны 2 дугаар ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 338 дугаар ангид ирсэн дайчдыг 2020 оны 10 дугаар сарын 14-нд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын нутагт байрлах Монгол Улсын төр, цэргийн зүтгэлтэн, Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга агсан хурандаа генерал Ж.Ёндонгийн дурсгалд зориулж бүтээсэн

"Соёмбо" цогцолбор, Сүхбаатарын төв талбай, "Өөлүн эх" цэцэрлэгт хүрээлэн, Чонотой хөшөө түүхэн дурсгалт газруудаар аялуулан аймаг орон нутгаа танилцуулах ажлыг зохион байгуулав.

Мөн хугацаат цэргийн алба хаагчдыг байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, бэлтгэлээр халагдаж буй дайчдад

дурсгалын зүйл, талархлын захидал, өөрсдийн гэрэл зургийг дурсган хадгалуулав. Албаа нэр төртэй хаан гэрийн зүг хүлгийн жолоо залж буй дайчдаа хандан ангийн захирагч, хурандаа П.Мөнхбат "Улс орон даяар тархаад буй хүнд өвчний үед алба хаасан хэдий ч Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жил, Монгол Улсад Барилгын салбар үүсэж хөгжсөний 95

жил, орчин цагийн Зэвсэгт хүчинд Барилгын цэрэг үүсэн байгуулагдсаны 85 жил, Зэвсэгт хүчний 338 дугаар анги үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн баяр энэ сайхан түүхэн үйл явдлуудын гэрч болон албаа нэр төртэй хаасан та бүгдээр эх орон, ээж аав тань бахархаж байгаа гэдгийг хэзээ ч битгий мартаарай" хэмээн дайчдаа үдэн гаргаж өглөө.

ЦЭРЭГ ТАТАХ АЖЛЫГ ЭНЭ САРЫН 15-30-НЫ ӨДРҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛНА



Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т "Монгол Улсын иргэн эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах" үндсэн үүргийг ёсчлон биелүүлэхээр заасан нь иргэн бүр цэргийн алба хаах харилцааны эрх зүйн суурь зохицуулалт болдог.

Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн Монгол Улсын иргэний цэргийн жинхэнэ алба хаахтай холбогдох харилцааг Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Цэргийн албаны тухай хууль болон бусад хуулиар зохицуулж байна.

Цэргийн албаны тухай хуулиар хугацаат цэргийн албанд татагдах иргэнд цэргийн жинхэнэ албанд татах тухай цэргийн зарлан дуудах мэдэгдэл хүргүүлдэг.

Зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр болон товлоосон газарт ирсэн байх үүрэгтэй. Зөрчлийн тухай Монгол Улсын хуулийн 15.17

дугаар зүйлд зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр, товлоосон газарт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол хүнийг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэсэн заалт үйлчилж байна.

2021 оны ээлжит цэрэг татах ажлыг 10 дугаар сарын 15-наас 30-ны өдрүүдэд зохион байгуулна. Энэ жилийн цэрэг татлага нь цар тахлын амаргүй нөхцөл байдалд явагдаж байгаагаараа онцлог байна.

Үүнтэй уялдуулан иргэдийг цэрэг татлагын байраар баг, хороогоор нь тодорхой хуваарийн дагуу оруулах, цэргийн албанд тэнцсэн иргэнийг аймаг, дүүргээс шууд цэргийн нэгтгэл, ангид хүргэх, оршин суугаа газарт аль болох ойрхон цэргийн нэгтгэл, ангид хуваарилах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээнийг авч хэрэгжүүлнэ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
ЖАНЖИН ШТАБ

"ТЭРБУМ МОД" ТАРИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 338 ДУГААР АНГИЙН ХАМТ ОЛОН НЭГДЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралд үг хэлэхдээ Монгол Улс тэрбум мод тарих төлөвлөгөөтэй байгаа талаар мэдэгдэж олон хүний талархлыг хүлээсэн.

Энэ хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, үндэсний томоохон компаниуд, ялангуяа БХЯ, ЗХЖШ, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн идэвхтэй хамрагдаж манлайлан оролцож байгаа. Үүний нэг жишээ нь Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн удирдлага хамт олон ангийн байрлал, албан тушаалын орон сууцандаа 600 ширхэг улиас, хайлаас мод тарив.

Түүнчлэн Баруун-Урт хотын үдэлт угталтын хаалга болох "Сайн яваарай" хөшөөний дэргэд зам дагуу мөн 600 ширхэг улиас, хайлаас мод тарьж нийт 1200 ширхэг мод тарьж "тэрбум мод" үндэсний

аянд нэгдэн аймаг орон нутгийнхаа ногоон хөгжилд хувь нэмрээ оруулж байна.

Бие бүрэлдэхүүн модоо суулгахдаа байгаль орчны мэргэжилтнээс мод суулгах, ургуулах, усалгаа, арчилгааны талаар мэдээлэл, зөвлөгөө авч мод суулгах нарийн журам зааврыг даган модоо суулгаж байгаа юм. Учир нь тал газар мод тарьсан тул зөвхөн модоо тариад орхих биш тарьсан модоо хүн, мал амьтнаас хамгаалах үүднээс торон хашаа татаж хамгаалсан. Бие бүрэлдэхүүнийг мод тарих үед аймгийн телевиз ирж сурвалжилга хийсэн бөгөөд ангийн захирагч, хурандаа П.Мөнхбат өгсөн ярилцлагадаа цаашид бид бүхэн энэхүү тарьсан модоо арчлалт, хамгаалалтад нь анхаарч ногоон төгөл болгон модоо ургуулах талаараа хэлж байлаа.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ